

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ
ГАЗРЫН ДАРГА

2025 оны 02 дугаар сарын 03



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 02 дугаар сарын 03

Улаанбаатар хот

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Төсөв	Хугацаа	Хариуцах хэлтэс
Нэг. Албан хаагчдын ажиллах нөхцөл, хангамжийг сайжруулах						
1.	Албан хаагчдын өдөр бүр ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн хэрэгслийн унааны зардлыг олгох асуудлыг шийдвэрлэх	Нөхөх төлбөр олгосон албан хаагчийн тоо	"Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.2, 8.4-т заасны дагуу хоол, унааны нөхөх төлбөр олгосон байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	I-IV улирал	Захиргаа удирдлагын хэлтэс
2.	Албан хаагчдад ажиллах нөхцөлөөр хангаж шаардлагатай бичиг хэргийн материалаар хангах	Гаргасан зардлын хэмжээ	Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2 дэх заалтад заасан ажиллах нөхцөлөөр хангасан байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	I-IV улирал	Захиргаа удирдлагын хэлтэс
3.	Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралт олгох	Ээлжийн амралт олгосон	Хөдөлмөрийн тухай хуульд заасан ээлжийн амралтыг албан хаагчдад	Батлагдсан төсвийн хүрээнд	I-IV улирал	Захиргаа удирдлагын хэлтэс

		албан хаагчийн тоо	олгож, ээлийн амралтын олговрыг олгосон байна.			
4.	Албан томилолтоор ажилласан албан хаагчдад албан томилолтын зардлыг олгох	Албан томилолтоор ажилласан тоо	Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт зааснаар дотоод албан томилолтоор ажилласан албан хаагчдад томилолтын зардлыг олгосон байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	I-IV улирал	Захиргаа удирдлагын хэлтэс
Хоёр. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
5.	Төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэв, түүний нэмэгдэл шинээр болон ахиулан олгох саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх	Зэрэг дэв шинээр болон ахиулан олгосон албан хаагчийн тоо	Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу албан хаагчдад зэрэг дэвийн мэгдлийг олгож, албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	I-IV улирал	Захиргаа удирдлагын хэлтэс
6.	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад хуульд заасан төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгох	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон албан хаагчийн тоо	“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу албан хаагчдад нэмэгдлийг олгож, албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	I-IV улирал	Захиргаа удирдлагын хэлтэс

7.	Албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэн, хагас бүтэн жилээр урамшуулал олгох	Урамшуулал олгосон албан хаагчийн тоо	Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т зааснаар албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн мөнгөн урамшуулал олгосон байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	I-IV улирал	Захиргаа удирдлагын хэлтэс
8.	Албан хаагчдын ар гэрт гачигдал тохиолдох, хүндээр өвдөх, урт хугацааны турш ажил хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд тусламж, дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх	Тусламж, дэмжлэг үзүүлсэн албан хаагчдын тоо	Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд үндэслэн албан хаагчдад тусламж, дэмжлэг үзүүлсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	I-IV улирал	Захиргаа удирдлагын хэлтэс
9.	Галлагаатай гэр байшинд амьдардаг ажилтан, албан хаагчдын өвөлжилтийн бэлтгэлд зориулан сайжруулсан шахмал түлш, худалдан авахад дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх	Дэмжлэг, хөнгөлөлт үзүүлсэн албан хаагчийн тоо	"Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.2, 8.4-т заасны дагуу сайжруулсан шахмал түлш, худалдан авахад дэмжлэг, хөнгөлөлт үзүүлсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	I-IV улирал	Захиргаа удирдлагын хэлтэс
10.	Ажил үүргээ идэвх зүтгэл, үр дүнтэй биелүүлж, өндөр амжилт гаргасан албан хаагчдыг шагнал урамшуулалд тодорхойлох	Шагнал урамшуулал д тодорхойлсон албан хаагчийн тоо	Ажилтан албан хаагчдын ажиллах урам зориг, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	I-IV улирал	Захиргаа удирдлагын хэлтэс

11.	Хөдөлмөрийн тухай хуульд заасан жирэмсний болон амаржсаны амралт, хүүхэд асрах чөлөө олгох	Амралт, чөлөө олгосон албан хаагчийн тоо	Хөдөлмөрийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.1, 137.5 дахь хэсэг, 139 дүгээр зүйлд заасны дагуу жирэмсний болон амаржсаны амралт, хүүхэд асрах чөлөө олгосон байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	I-IV улирал	Захиргаа удирдлагын хэлтэс
12.	Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгох	Өндөр насны тэтгэвэрт гарч тэтгэмж олгосон албан хаагчийн тоо	Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт заасны дагуу өндөр насны тэтгэвэрт гарч чөлөөлөгдсөн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	I-IV улирал	Захиргаа удирдлагын хэлтэс
Гурав. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах						
13.	Албан хаагчдын хувийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэн, Төрийн албаны зөвлөлөөс шинэчлэн боловсруулсан ХНУМТ-т системд мэдээллийн санг бий болгож өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах	Хувийн хэргийг цахимжуулсан албан хаагчийн тоо	“Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж, албан хаагчдын хувийн хэргийг цахимаар болон цаасан хэлбэрээр бүрэн бүрдүүлж, баталгаажуулсан байна.	-	I-IV улирал	Захиргаа удирдлагын хэлтэс
14.	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр	Байршуулсан	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай	-	I-IV улирал	Захиргаа удирдлагын хэлтэс

авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудаст ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх, тухай бүр шинэчлэх	мэдээллийн тоо	хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.			
--	-------------------	---	--	--	--

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА



/Т.ОЮУНТУУЛ/

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАН ШАЛГАСАН:

ӨМЧИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



/М.Дарваипов/

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН.

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



/Г.ДАВААМӨНХ/